



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, 6.3, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүтээгдэхүүний дээж шинжлэх журам”-ыг нэгдүгээр, “Лабораторийн шинжилгээнд дээж хүлээн авах тоо, хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм шинжлэх лаборатори (Ш.Энхзаяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Батзориг)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын  
газрын даргын 2022 оны ..... дугаар сарын .....-ны  
өдрийн ..... дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДЭЭЖ ШИНЖЛЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Лабораторид хэрэглэгчийн /хүсэлт гаргагчийн/ ирүүлсэн дээжийг батлагдсан тоо хэмжээгээр хүлээн авч, бүртгэх, шинжилгээнд оруулах, шинжилгээний дүнгийн хуудсыг олгох үйл ажиллагааг явуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Тухайн дээжийг Фармакопейн арга аргачлал, үзүүлэлтийг үндэслэн дээжийн тоо хэмжээг тогтоож баримтална.

1.3.Дээж хүлээн авах үйл ажиллагаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журам, MNS ISO/IEC 17025:2018 стандарт, Эм шинжлэх лабораторийн менежментийн тогтолцооны журам, Дээжтэй харьцах журам болон бусад холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.

### Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1.“Дээжийн тодорхойлолт” гэж тухайн дээжийг шинжлэх үзүүлэлт, аргачлал, тоо хэмжээ, хугацаа, шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлсэн баримт бичгийг;

2.2.“Дээж” гэж хяналт шалгалтын явцад бүтээгдэхүүнээс стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар мэдээлэл авах, шийдвэр гаргах зорилгоор шинжилгээнд авсан нэгжийн бүрдлийг;

2.3.“Дээжийн хэмжээ” гэж тухайн сонгон авсан бүтээгдэхүүн бүрэн төлөөлж чадах, шаардлага гарсан тохиолдолд шинжилгээг давтан хийхэд хүрэлцэхүйц хэмжээг;

2.4.“Загвар дээж” гэж лабораторийн гадаад, дотоод хяналт, шинжилгээний дүнг баталгаажуулах зорилгоор лабораторит хадгалж байгаа дээжийг;

2.5.“Бүтээгдэхүүн” гэж улсын хил, гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх болон зах зээлд худалдаалагдаж буй ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн, сав баглаа боодол, тэдгээрийн түүхий эд материалыг;

### Гурав. Лабораторийн эрх, үүрэг

#### 3. Лабораторийн эрх

3.1. Аж ахуйн нэгж, албан байгууллагын албан хүсэлтээр ирүүлсэн дээж, холбогдох материалтай ажлын 1-2 хоногийн дотор танилцаж шинжилгээнд хамруулана.

3.2.Цагдаа, тагнуулын байгууллага, улсын байцаагчийн албан хүсэлтээр лабораторийн шинжилгээнд хамруулахаар ирүүлсэн дээж, баримт бичигт дүн шинжилгээ хийж, шинжилгээнд шууд хамруулна.

3.3 Шинжилгээ хийх гүйцэтгэх хугацааг бүтээгдэхүүний стандарт, аргачлалд заасан хугацааг баримтлана.

3.4.Лабораторид шаардлага хангаагүй дээжид давтан шинжилгээ хийх үед шинжилгээний хугацааг лабораторийн удирдлагаас сунгаж, тогтоож болно.

3.5.Лабораторийн шинжилгээнд хамруулахаар ирүүлсэн дээж батлагдсан тоо хэмжээнд хүрээгүй, баримт бичиг дутуу тохиолдолд нэмж өгөхийг мэдэгдэнэ.

#### 3.2. Лабораторийн үүрэг

3.2.1.Лабораторийн шинжилгээнд хамруулахаар ирүүлсэн дээжийг, батлагдсан хугацаанд шинжилгээ хийж гүйцэтгэнэ.

3.5.Дээж хүлээн авагч улсын байцаагчийн тэмдэглэл, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын шинжилгээ хийлгэх тухай хүсэлтийг үндэслэн батлагдсан тарифийн дагуу шинжилгээний төлбөрийн нэхэмжлэлийн хуудсыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад бичиж өгнө.

3.3.Лабораторийн шинжилгээ бүрэн хийгдсэн дээжийн шинжилгээний дүнг гарсан өдөрт холбогдох улсын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мэдэгдэнэ.

#### **Дөрөв. Дээж хүлээн авах**

4.1 Лаборатори шинжилгээнд хамруулах дээжийн хүсэлтийг эмийн бүртгэлийн хэлтэс, гааль, эм биобэлдмэлийн улсын байцаагч, цагдаа, тагнуул, эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, эмийн сан, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага)-аас хүлээн авна. Эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, хугацаа нь хүчинтэй байна.

4.2.Шинжилгээнд ирүүлсэн дээжид дараах хяналт хийнэ Үүнд:

4.2.1.Дээжийн битүүмжлэл;

4.2.2.Бүтээгдэхүүний болон худалдааны нэр, үндсэн үйлчлэгч бодис;

4.2.3.Бүтээгдэхүүний хэлбэр, тун хэмжээ, үндсэн үйлчлэгч бодисын агууламж;

4.2.4.Дээжийн тоо хэмжээ;

4.2.5.Савлалт, хаяглалтын байдал, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, бүтээгдэхүүний улсын бүртгэлийн дугаар, цувралын дугаар, марк үйлдвэрлэсэн ба хүчинтэй хугацаа;

4.2.6.Анхдагч ба хоёрдогч савалгааны байдал, тэдгээрийн хоорондын таарц;

4.2.7.Дээжийн гадаад бүрэн бүтэн байдал ба онцлох өвөрмөц байдал;

4.3.Дээж шаардлага хангаагүй (дээжийн савлагаа гэмтсэн, битүүмжлэл алдагдсан, асгарсан, гоожсон хорогдсон, тоо хэмжээ хүрэлцээгүй, хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй, дээжийн дагалдах баримт бичиг зөрүүтэй, стандарт бодис, аргын баталгаажуулалтын тайлан байхгүй) бол хүлээн авахгүй буцаана.

4.4.Шинжээч хуваарилагдаж ирсэн дээжийн аргачлалтай танилцаж, шинжилгээг хийх явцад шинжилгээний арга аргачлал зөрүүтэй, үндэсний фармакопейн өгүүлэл (ҮФӨ) төслийн баримт бичиг алдаатай зөрүүтэй дутуу тохиолдолд баримтжуулж, чанар хариуцсан ахлах мэргэжилтэн лабораторийн удирдлагын зөвшөөрлөөр буцаана.

4.5.Хэрэв хүлээн авч байгаа дээжийн баримт бичгийн бүрдэл дутуу, анхан шатны маягтыг бүрэн бус бөглөсөн, дээж нь мэдээллээс зөрүүтэй байвал хүсэлт гаргагчид мэдэгдэж хариу иртэл “Хүлээгдэж байгаа дээжийн бүртгэл”-д бүртгэж ажлын 5 хоног хадгалах ба энэ хугацаанд хариу өгөөгүй бол энэ талаар лабораторийн даргад танилцуулж буцаана.

4.6.Цагдаа, тагнуулын байгууллага, байцаагчаас ирүүлсэн дээжийг шинжилгээнд шууд хамруулна. Албан бичгээр болон бүртгэлийн дээжийг бичиг хэргээр бүртгэж, цохолт хийгдсний дараа дээжийг хүлээн авна.

4.6.Дээж хүлээн авагч шинжилгээнд ирж буй дээж, бичиг баримтын бүрэн эсэхэд хяналт хийнэ. Үүнд:

4.6.1.Албан бичиг;

4.6.2.Лабораторид дээж өгсөн тэмдэглэл;

4.6.3.Бүтээгдэхүүнээс дээж авсан тэмдэглэл;

4.6.4.Бүтээгдэхүүний шинжилгээний гэрчилгээ (анализ сертификат);

4.6.5.Бүртгэлийн дээжид эцсийн бүтээгдэхүүний техникийн шаардлага, шинжилгээний аргачлал, аргын баталгаажуулалтын тайлан (цаасан ба цахим-электрон хэлбэрээр);

4.6.6.Стандарт бодис, түүний анализ сертификат;

4.6.7.Шаардлагатай тохиолдолд тухайн дээжний шинжилгээнд өвөрмөц ховор ашиглагддаг урвалж, багана, аргын баталгаажилт;

4.6.8.Эм үйлдвэрлэгчийн үндэсний фармакопейн өгүүлэл ҮФӨ (шаардлагатай тохиолдолд);

4.6.9.Төлбөр төлсөн баримт;

- 4.6.11.Лабораторийн шинжилгээ хийлгэх хүсэлтийн маягт бөглөсөн;
- 4.7.Хүлээн авсан дээжийг стандарт ажлын зааврын дагуу бүртгэж, хуваарилна.
- 4.8.Дээж хүлээн авагч шинжилгээний төлбөрийн нэхэмжлэхийг шинжилгээний хүсэлтэд үндэслэн, батлагдсан тарифийн дагуу бичиж, байгууллагад өгөх ба бүртгэл хөтөлнө.
- 4.9.Дээж хүлээн авагч шинжээч шинжилгээний төлбөр тооцоо хийсэнг хянаж шинжилгээний дүнг бүртгэж, олгосон тухай гарын үсгээр баримтжуулна.
- 4.10. Шинжилгээний дээжийн хариуг шинжилгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд олгоно.
- 4.11. Загвар дээжийг хэрэглээгүй, шинжилгээний дээжийн хариу бүрэн гарсан тохиолдолд загвар дээжийг шинжилгээний хариутай хамт тухайн хүсэлт гаргагчдад хүлээлгэн өгсөн бүртгэл хөтөлж баримтжуулна.
- 4.12.Шинжилгээний төлбөрөөс чөлөөлөх дээж Үүнд:
- 4.12.1.Гэмт хэргийн шинжтэй дээж (цагдаа, тагнуулын байгууллага) албан бичгээр ирүүлсэн, шинжилгээний төлбөр төлөх субъект тодорхой бус, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор хийгдэх шинжилгээ;
- 4.12.2.Итгэмжлэлийн хүрээнд шинжилгээ гүйцэтгэх чадварыг үнэлэх, үр дүнгийн чанарыг хянах зорилгоор лаборатори хоорондын харьцуулсан шинжилгээ;
- 4.12.3. Тандалт судалгааны шинжилгээ;
- 4.13.Шинжилгээнд хамруулах хүсэлтийн өргөдлийн маягтыг дээж хүлээн авах хэсэгт хадгалан, улирал тутам дүн шинжилгээ хийж, жилийн эцэст архивлана.
- 4.14.Шинжилгээний гэрээний хэрэгжилт, хугацаанд жил тутам дүн шинжилгээ хийнэ.
- 4.15.Бүртгэлийн баримт бичгийг бүртгэлийн хяналтын журмын дагуу хадгална.

#### **Тав. Лабораторийн шинжилгээ**

5.1.Шинжилгээний дээж, хүсэлтийг хүлээн авахдаа шинжилгээний үзүүлэлт (итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт)-ийг үндэслэн лабораторийн чадамж, нөөцтэй нийцэх эсэхэд техник хариуцсан ахлах шинжээч дүн шинжилгээ хийж, шинжилгээнд хамруулна.

5.2 Дээж хүлээн авагч дээжийг журамд заасан тоо хэмжээгээр шинжээчид хүлээлгэн өгч баримтжуулна.

5.3.Шинжилгээг заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн байна Үүнд:

5.3.1.Ариун эмийн шинжилгээ ажлын 20 хоног;

5.3.2.Бусад шинжилгээ эмийн хэлбэр, найрлага, шинжилгээний үзүүлэлтээс хамаарч ажлын 7-10 хоног;

5.3.3. Шаардлагатай тохиолдолд давтан шинжилгээ ажлын 10-14 хоног;

5.4.Дээжийг хүлээн авахдаа амархан муудах, яаралтай шинжилгээ хийх шаардлагатай тохиолдолд дээжийг хуваарилан, улаан тууз нааж, шинжилгээнд оруулах талаар чанар хариуцсан ахлах мэргэжилтэн холбогдох шинжээчид мэдэгдэнэ.

#### **Зургаа. Дээжийг бүртгэх, хаяглах**

6.1 Хүлээн авсан дээжийн цаасан ба удирдлагын тогтолцооны цахим програмд бүртгэнэ.

6.2.Бүртгэл дараах мэдээллийг агуулна Үүнд:

6.2.1.Хүлээн авсан дээжийн тоо хэмжээ;

6.2.2.Шинжлэх үзүүлэлт, аргын тоо;

6.2.3.Шинжилсэн нийт үзүүлэлтийн тоо

6.2.4.Шинжилгээний дүн гарсан огноо;

6.2.5.Шинжилгээний дүн;

6.2.6.Шаардлага хангаагүй үзүүлэлтийн нэр, тоо;

6.2.7 Шинжилгээний хугацаа хэтрэлт;

6.2.8.Давтан шинжилгээнд орсон;

6.2.9.Шинжилсэн дээжийн мэдээлэл;

- 6.2.3.Шинжилгээний төлбөр;
- 6.2.4.Шинжилгээний хариуг эргэн мэдээлсэн;
- 6.3.Дээж хүлээн авагч дээж тус бүрийн савлагаанд бүртгэлийн дугаар, шинжээчийн кодыг бичсэн дараах өнгийн туузыг нааж, хаягжуулна Үүнд:
- 6.3.1.Энгийн дээжинд ногоон өнгийн тууз (электрон бүртгэлд хамаарахгүй);
- 6.3.2.Бүртгэлийн дээжинд шар өнгийн тууз;
- 6.3.3.Хордлого гомдол, яаралтай дээжинд улаан өнгийн тууз;
- 6.3.4.Байцаагчаас ирсэн дээжинд улбар шар өнгийн тууз;
- 6.3.5.Бүртгэл сунгалтын дээжинд ягаан өнгийн тууз;
- 6.3.6. Тандалт судалгааны дээжинд улбар шар өнгийн тууз;
- 6.4.Мэдээлэл удирдлагын тогтолцооны цахим программаар шинжээч тус бүрт шинжилгээ хийх үзүүлэлтийг хуваарилан оруулж, бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.
- 6.5.Хэрэв шинжээчид хуваарилагдсан дээжийг нэг шинжээчээс нөгөө шинжээч рүү шилжүүлэх тохиолдолд (ар гэрийн гачигдал гарсан, удаан хугацаагаар өвдөх) лабораторийн даргын зөвшөөрлийг үндэслэн шинжээчийг сольж хуваарилна.
- 6.6.Шинжилгээнд ирүүлсэн дээжнээс загвар дээжийг журмын дагуу авч бүртгэлийн дугаар бүхий тууз нааж хаягжуулан лабораторийн няравт ажлын 3 хоногт багтаан хүлээлгэн өгч баримтжуулна.
- 6.7.Загвар дээжнээс шинжилгээнд хамруулахад бүртгэж, баримтжуулна.
- 6.8. Лабораторийн нярав тухайн бүтээгдэхүүний шинжилгээний дүнг загвар дээжийн хамт хүсэлт гаргагчид буцаан олгож бүртгэж, баримтжуулах ба баримт нотолгооны хамт тайланг сар бүр гаргаж мэдээлнэ.
- 6.9.Шинжилгээ дүн, загвар дээжийн буцаан олгож шинжилгээнд хамруулсан тухай бүртгэл, баримт нотолгооны хамт тайланг сар бүр гаргаж мэдээлнэ.
- 6,10.Тухайн цуврал бүтээгдэхүүн маш бага хэмжээтэй эсвэл өндөр үнэтэй эмийн бүтээгдэхүүн байвал зөвхөн нэг удаагийн шинжилгээний дээж авна.
- 6.11.Эмийн түүхий эд, ус, хий, идэмхий, галд шатамхай эхлэл материал болон эмийн ургамлаас хадгалах дээж авахгүй.
- 6.12. Эмийн зйлдвэрийн түүхий эдийг фармакопейн шинжилгээнд бүрэн хамруулна.


#### **Долоо.Стандарт бодис, урвалж**

- 7.1.Шинэ бүртгэл, сунгалтын /үндэсний фармакопей MNS төсөл/ дээжийг шинжилгээнд хамруулахдаа нэмэлтээр стандарт бодис, хольцын стандарт, плацебо бодисыг холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч, тухайн өдөрт нь хариуцсан лаборантад хүлээлгэн өгч, бүртгэл хөтөлнө.
- 7.2. Шинэ бүртгэл, сунгалтын дээжийг шинжилгээнд хамруулахдаа шаардлагатай тохиолдолд нэмэлтээр шинжилгээнд хэрэглэгдэх стандарт бодис,хроматографын багана, урвалж бодисыг техник хариуцсан ахлах шинжээч нарын хяналтан дор хүлээн авч, бүртгэл хөтөлж баталгаажуулна.

#### **Найм. Хүлээлгэх хариуцлага**

- 8.1. Дараах тохиолдолд ажлын хариуцлага тооцно. Үүнд:
- 8.1.1.Иргэд үйлчлүүлэгчтэй зүй бус харьцах, доромжлох, ёс зүйн зөрчил гаргах;
- 8.1.2.Үйлчлүүлэгч, иргэдтэй маргаан үүсгэх, зүй бус харьцах;
- 8.1.3. Шинжилгээний хэвийн үйл ажиллагаа тасалдахад хүргэсэн, тасалдуулсан;
- 8.1.4.Шинжилгээнд ирсэн дээж, стандарт бодис, дутаах, алга болгох;
- 8.1.5.Шинжилгээний хариуг буруу гаргах, тэнцээгүй үзүүлэлтийг хасах;
- 8.1.6.Загвар дээжийг буцаан олгоогүй, шамшигдуулсан;
- 8.1.7. Шинжилгээний дээжийг заасан тоо хэмжээнээс хэтрүүлж авах;

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын  
газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 08-ны  
өдрийн 8/184 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ДЭЭЖ  
ХҮЛЭЭН АВАХ ТОО, ХЭМЖЭЭ

| №  | Эм, БИБ, эмнэлгийн хэрэгслийн нэр                                                                                               | Тун хэмжээ  | Хэмжих нэгж | Дээжийн тоо хэмжээ |               |             | Нийт |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------|--------------------|---------------|-------------|------|
|    |                                                                                                                                 |             |             | Хими               | Микро-биологи | Загвар дээж |      |
| 1  | Тун шилтэй эм                                                                                                                   | 1мл         | ампул       | 30                 | 20            | 5           | 55   |
|    |                                                                                                                                 | 2мл         |             | 20                 | 20            | 5           | 45   |
|    |                                                                                                                                 | 10мл ≤      |             | 10                 | 15            | 5           | 30   |
|    |                                                                                                                                 | 5мл         |             | 10                 | 15            | 5           | 30   |
| 2  | Шахмал, үрэл, капсул /шахмал, капсул хэлбэрт орсон уламжлалт эм/                                                                |             | ширхэг      | 50                 | 20            | 10          | 80   |
| 3  | Шахмал, капсул /16листрт 2 ба түүнээс дээш олон улсын өөр нэршил багц бүхий эм багтсан, эм болон өдрийн уух тунгаар савлагдсан/ |             | ширхэг      | 70                 | 20            | 10          | 100  |
| 4  | Тосон түрхлэг                                                                                                                   | 10г ≤       | ширхэг      | 7                  | 3             | 0           | 10   |
|    |                                                                                                                                 | ≤5г ≤       | ширхэг      | 5                  | 5             | 0           | 10   |
| 5  | Тарилгын шингэн                                                                                                                 | 10-50мл     | флакон      | 10                 | 2             | 0           | 12   |
|    |                                                                                                                                 | 50мл        |             | 5                  | 2             | 0           | 7    |
|    |                                                                                                                                 | 50мл ≤      |             | 5                  | 2             | 0           | 7    |
| 6  | Эмийн түүхий эд                                                                                                                 |             | гр          | 70                 | 30            | 0           | 100  |
| 7  | Галены бэлдмэл                                                                                                                  | 30 мл       | ширхэг      | 10                 | 2             | 0           | 12   |
|    |                                                                                                                                 | 100 мл      |             | 10                 | 3             | 0           | 13   |
|    |                                                                                                                                 | 200 мл ≤    |             | 10                 | 3             | 0           | 13   |
| 8  | Эмийн сангийн бэлдмэл                                                                                                           | 200 мл      | флакон      | 3                  | 1             | 0           | 4    |
|    |                                                                                                                                 | 10 мл       |             | 10                 | 3             | 0           | 13   |
| 9  | Тарилгын антибиотик                                                                                                             |             | флакон      | 30                 | 15            | 10          | 55   |
| 10 | Ургамлын түүхий эд                                                                                                              |             | гр          | 50                 | 10            | 0           | 60   |
| 11 | Дуслын систем                                                                                                                   |             | ширхэг      | 3                  | 6             | 0           | 9    |
| 12 | Нүд, чих, хамрын дусал                                                                                                          | 5-10 мл     | флакон      | 10                 | 5             | 0           | 15   |
| 13 | Нэг удаагийн тариур                                                                                                             | 50 мл       | ширхэг      | 10                 | 5             | 0           | 15   |
|    |                                                                                                                                 | 20 мл       |             | 10                 | 10            | 0           | 20   |
|    |                                                                                                                                 | 10 мл       |             | 15                 | 10            | 0           | 25   |
|    |                                                                                                                                 | 5 мл        |             | 15                 | 15            | 0           | 30   |
|    |                                                                                                                                 | 3 мл        |             | 15                 | 15            | 0           | 30   |
|    |                                                                                                                                 | 1 мл        |             | 15                 | 15            | 0           | 30   |
|    |                                                                                                                                 | 0.5 мл      |             | 30                 | 15            | 0           | 45   |
| 14 | Мэс заслын утас                                                                                                                 |             | ширхэг      | 5                  | 6             | 0           | 11   |
| 15 | Мэс заслын бээлий                                                                                                               |             | ширхэг      | 5                  | 6             | 0           | 11   |
| 16 | Хөвөн                                                                                                                           | 50 г        | ширхэг      | 5                  | 5             | 0           | 10   |
|    |                                                                                                                                 | кг          | гр          | 100                | 50            | 0           | 150  |
| 17 | Бинт                                                                                                                            | ариутгас ан | ширхэг      | 10                 | 5             | 0           | 15   |

|    |                                                                                        |                        |         |                              |    |    |    |
|----|----------------------------------------------------------------------------------------|------------------------|---------|------------------------------|----|----|----|
|    |                                                                                        | ариутга<br>агүй        | ширхэг  | 10                           | 5  | 0  | 15 |
| 18 | Марль                                                                                  |                        | метр    | 5                            | 0  | 0  | 5  |
| 19 | Нэг удаагийн бээлий                                                                    | хайрцаг                | ширхэг  | 1                            | 0  | 0  | 1  |
| 20 | Бэлгэвч                                                                                |                        | ширхэг  | 20                           | 5  | 0  | 25 |
| 21 | Тугнасан нунтаг, мөхлөг                                                                | 1-3г                   | ширхэг  | 50                           | 20 | 0  | 70 |
|    |                                                                                        | 5г                     | ширхэг  | 50                           | 10 | 0  | 60 |
|    |                                                                                        | 10г<br>хүртэл          | ширхэг  | 50                           | 10 | 0  | 60 |
| 22 | Лаа                                                                                    |                        | ширхэг  | 40                           | 20 | 10 | 70 |
| 23 | Сироп, хөвмөл                                                                          |                        | флакон  | 10                           | 2  | 5  | 17 |
| 24 | Хурууны лент                                                                           | ариутгас<br>ан         | ширхэг  | 0                            | 15 | 0  | 15 |
|    |                                                                                        | ариутга<br>агүй        | ширхэг  | 0                            | 15 | 0  | 15 |
| 25 | БИБ / том савлагаатай<br>уураг, коктейль, 130-с<br>дээш савлагаатай<br>шахмал, капсул/ |                        | ширхэг  | 1 /дамжин<br>шинжилгээ хийх/ |    | 1  | 2  |
| 26 | Конбинзон                                                                              |                        | ширхэг  | 3                            | 3  | 0  | 6  |
| 27 | Амны хаалт (Mask )                                                                     | хайрцаг                | ширхэг  | 1                            | 1  | 0  | 2  |
|    |                                                                                        | 1ш-р<br>савлагд<br>сан | ширхэг  | 30                           | 10 | 0  | 40 |
| 28 | Бусад эмнэлгийн<br>хэрэгсэл /өвдөгний үе,<br>шүдний имплант протез/                    |                        | ширхэг  | 0                            | 2  | 1  | 3  |
| 29 | Биобэлдмэл туншил                                                                      | 1-1.5мл                | ампул   | 30                           | 20 | 0  | 50 |
|    |                                                                                        | 2мл                    | ампул   | 20                           | 20 | 0  | 40 |
| 30 | Биобэлдмэл тарилга                                                                     |                        | флакон  | 1                            | 2  | 1  | 4  |
| 31 | Уламжлалт<br>/тугнагдсан/ эм                                                           | 1ш-р<br>савлагд<br>сан | тан эм  | 30                           | 30 | 0  | 60 |
|    |                                                                                        | 1ш-р<br>савлагд<br>сан | талх эм | 30                           | 30 | 0  | 60 |
|    |                                                                                        | 1ш-р<br>савлагд<br>сан | үрэл эм | 40                           | 30 | 0  | 70 |
| 32 | Нэрмэл ус /тарилгын ус,<br>цэвэршүүлсэн ус/                                            | 500мл ≤                | флакон  | 1                            | 1  | 0  | 2  |
| 33 | Диализ ус                                                                              | 100мл ≤                | флакон  | 3                            | 3  | 0  | 6  |
| 34 | Ариутгалын бодис                                                                       | 10-<br>100мл           | флакон  | 10                           | 5  | 0  | 15 |
|    |                                                                                        | 100мл ≤                | флакон  | 10                           | 5  | 0  | 15 |
|    |                                                                                        |                        | ширхэг  | 50                           | 30 | 0  | 80 |

--ooOOoo--